# ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

| Зөвшөөрлийн тухай хуульд заасан зөвшөөрөл | Салбар хуулийн дагуу олгож байгаа зөвшөөрөл | Зөвшөөрөлд тавигдах шаардлага /хууль болон журам/ | Үйл ажиллагааны процесс | Зөвшөөрлийн онцлог |
|---|---|---|---|---|
| Цэцэрлэгийн үйл ажиллагаа эрхлэх | - | Зөвшөөрлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 | Боловсролын сайдын тушаалыг үндэслэн олгоно. | Сургуулийн өмнөх боловсрол эрхлэх зөвшөөрлийг олгох |
| Ерөнхий боловсролын сургууль байгуулах | - | Зөвшөөрлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 | Боловсролын сайдын тушаалыг үндэслэн олгоно. | Ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааг эрхлэх |
| Сувилахуйн дагнасан тусламж үйлчилгээ | Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 13.10, Эрүүл мэндийн тухай хуулийн 15 дугаар зүйлийг баримтлан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллагад төрөл тус бүрээр тусгай зөвшөөрлийг олгож байна. | Эрүүл мэндийн тухай хуулийн 19.18-ийг баримтлан Тусгай зөвшөөрлийг тухайн байгууллагад анх удаа бол 3 жил, сунгаж байгаа бол 5 жил гэсэн хугацаагаар олгож сунгаж байна.<br><br>Зөвшөөрлийн тухай хуулийн 5.1 дүгээр зүйлийн 3-т зааснаас гадна Эрүүл мэндийн тухай хуулийн 19.10 болон Эрүүл мэндийн сайдын 2023 оны А/100, А/383 дугаар тушаалыг баримтлан бичиг баримтыг бүрдүүлэн, | Шинээр тусгай зөвшөөрөл хүсэж байгаа байгууллагад зөвшөөрөл олгохдоо 2 үе шаттай зохион байгуулдаг.<br><br>1. Эрүүл мэндийн сайдын 2023 оны 3 дугаар сарын 24-ний өдрийн А/100 дугаар тушаалд зааснаар баримт бичиг болон үйл ажиллагааны төслийг ирүүлэх бөгөөд Комисс нь хүлээн авч баримт бичиг шинжээч томилон ажиллуулж, шинжээчийн дүгнэлтийг үндэслэн төслийг дэмжих эсэхийг шийдвэрлэнэ.<br>2. Төсөл дэмжигдсэн тохиолдол Зөвшөөрлийн тухай хуулийн 5.1 дүгээр зүйлийн 3-т зааснаас гадна Эрүүл мэндийн тухай хуулийн 19.10 болон Эрүүл мэндийн сайдын 2023 оны А/100, А/383 дугаар тушаалыг | Хүний эрүүл мэндтэй холбоотой тул олон төрлийн баримт бичиг бүрдүүлэх, хугацаа их шаардлагатай байдаг |
| Эмнэлгийн мэргэшсэн тусламж үйлчилгээ эрхлэх | Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 13.12, Эрүүл мэндийн тухай хуулийн 15 дугаар зүйлийг баримтлан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллагад төрөл тус бүрээр тусгай зөвшөөрлийг олгож байна. | | | |
| Ахуйн шавьж мэрэгч устгах, ариутгах, халдваргүйжүүлэх бодис худалдах | Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 13.15-ыг баримтлан тусгай зөвшөөрлийн олгож байна | | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| болон үйлчилгээ эрхлэх | | бүрдүүлсэн баримт бичиг, шинжээчийн дүгнэлтийг харгалзан Тусгай зөвшөөрөл олгох комиссоор шийдвэрлэн ажиллаж байна.<br><br>Тусгай зөвшөөрлийг хүчингүй болгоход Зөвшөөрлийн тухай хуулийн 6.2 дугаар зүйл болон Эрүүл мэндийн тухай хуулийн 19.20 дахь хэсгийг баримтлан ажиллаж байна. | баримтлан бичиг баримтыг бүрдүүлэн, ажлын байранд шинжээчийг томилон ажиллуулж, дүгнэлтийг үндэслэн шинээр олгох эсэхийг шийдвэрлэнэ.<br><br>Тусгай зөвшөөрөл сунгаж буй тохиолдолд Зөвшөөрлийн тухай хуулийн 5.5, Эрүүл мэндийн тухай хуулийн 19.17 болон Эрүүл мэндийн сайдын 2023 оны А/100, А/383 дугаар тушаалыг баримтлан бичиг баримтыг бүрдүүлэн Комиссын хурлаар шийдвэрлэнэ. | |
| Эм, эмнэлгийн хэрэгсэл, мансууруулах эм худалдах | Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 13.19, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3, 6.4 -ыг баримтлан тусгай зөвшөөрлийн олгож байна | | | |
| Өрхийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ эрхлэх | Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 13.20, Эрүүл мэндийн тухай хуулийн 15 дугаар зүйлий 15.1.1-ийг баримтлан тусгай зөвшөөрлийг олгож байна. | | | |